



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/208

Улаанбаатар хот

Монголын бүх ард түмний спортын
өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн
спортын өвлийн VII наадмыг 2023 онд
зохион байгуулах эрх олгох тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Спортын наадам хойшлуулах тухай” 268 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам” 183 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан 3.7 дахь заалт, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2022 оны А/196 дугаар тушаалаар батлагдсан “Ажлын хэсэг”-ийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам”, “Хүүхдийн спортын өвлийн VII наадам”-ыг 2023 онд Орхон аймагт зохион байгуулах эрхийг олгосугай.

2.Эдгээр наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангах, аймгаас гарах төсөв, төлөвлөгөөг батлуулах, ажлын явцын мэдээллийг тухай бүрт нь тайлагнаж байхыг Орхон аймгийн Биеийн тамир, спортын газар /Д.Дэлгэрбаяр/-т даалгасугай.

3.Наадмыг зохион байгуулах гэрээ байгуулах, нэгдсэн зааврыг 2022 оны 11 сард багтаан хэлэлцүүлэн батлуулж, наадмын бэлтгэл ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, зохицуулалт хийж ажиллахыг Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтэс /Б.Нямсүрэн/-т үүрэг болгосугай.

4.Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадам зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зардлыг 2023 оны төсөвт тусган санхүүжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Б.Долгион/-д зөвшөөрсүгэй.

5.“Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам”, “Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадам”-ын санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг наадам дууссанаас хойш ажлын 30 хоногт багтаан Биеийн тамир, спортын улсын хороонд ирүүлэхийг Орхон аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга /Д.Дэлгэрбаяр/-т үүрэг болгосугай.

6.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын газрын дарга /О.Баттулга/-д даалгасугай.

ДАРГА



Д.ЖАРГАЛСАЙХАН

142202108